



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/167

Булган сум

**Шууд худалдан авах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Соёл, урлагын газрын тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр “БСБ МЕБЕЛЬ” ХХК-тай 4 889 100 (Дөрвөн сая найман зуун наян есөн мянга нэг зуу) төгрөгөөр, “БСБ ЭЛЕКТРОНИКС” ХХК-тай 5 000 000 (Таван сая) төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Соёл, урлагын газар (Г.Алдармөнх)-т олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Соёл, урлагын газар (Г.Алдармөнх)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “БСБ МЕБЕЛЬ” ХХК-ийн ахлах худалдааны зөвлөх (Ж.Болорцэцэг), “БСБ ЭЛЕКТРОНИКС” ХХК-ийн менежер (М.Уранбайгаль) нарт тус тус даалгасугай.

4. Тус барааг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010125